# МОНГОЛ УЛСЫН
# БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
# САЙДЫН ТУШААЛ

2009 оны 12 сарын 24 өдөр Дугаар 591 Улаанбаатар хот

Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн "Журам батлах тухай" 177 тоот тогтоолоор баталсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам", Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар баталсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам"-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хишигдорж овогтой Баасанхүүг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар Шинэ Зеланд Улсын Auckland-ын их сургулийн магистрантурт "Олон улсын харилцаа-эрх зүй" чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар, Дагваа овогтой Отгонжаргалыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Америкийн Нэгдсэн Улсын Los Angeles хотын Калифорнийн улсын их сургулийн магистрантурт төрийн захиргааны удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар, Ламжав овогтой Цэнгүүнжавыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Америкийн Нэгдсэн Улсын George Washington их сургуулийн магистрантурт улс төрийн удирдлагын чиглэлээр 3 жилийн хугацаатайгаар, Галцог овогтой Цогтбаатарыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар Япон улсын Канагавагийн үйлдвэрлэл, технологийн дээд сургуулийн бакалаврын шатны сургалтанд мэдээлэл, технологийн чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар тус тус суралцуулсугай.

2. "Гадаадад зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 294 дүгээр тушаалын Жанцанноровын Дамдинцэрэнтэй холбогдолтой хэсгийн суралцах хугацааг "2 жил" гэснийг "3 жил" болгож өөрчилсүгэй.

3. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу

суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД Ё.ОТГОНБАЯР